



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг,
Утас: 7059-2494, Факс: 7059-2896,
E-mail: info@dundgovi.gov.mn

2018.04.30 № 2/430

танай _____ -ны № _____ -т

Г Үүрэг даалгавар хүргүүлэх тухай Г

Г ДУНДГОВЬ АЙМГИЙН НУТАГ
ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ
БУЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАРГА
УДИРДЛАГУУДАД Г

Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд болон Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллага /яам/, Засгийн газрын агентлагуудын ажлын уялдааг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн төрийн байгууллагуудын ажлын эхлэх, дуусах цагийг Өвөл цагийн болон Зун цагийн хуваарьт шилжүүлэн ажилладаг байсан уламжлалыг сэргээж, та бүхний болон иргэд олон нийтийн саналыг харгалзан тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудыг 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд ажлын цагийг 08 цаг 00 минутад эхлүүлж, 17 цаг 00 минутад дуусахаар зохицуулахыг үүрэг болгосон аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 30-ны А/193 дугаар захирамж гарсныг хүргүүлж байна.

Энэхүү үүрэг даалгаврын дагуу байгууллагынхаа ажлын эхлэх, дуусах цагийн зохицуулалтыг дотоод журамдаа тусган мөрдөх нь зүйтэй.

Ийнхүү ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулснаар төрийн захиргааны төв байгууллагуудын үйл ажиллагаатай орон нутаг дахь төрийн байгууллагуудын үйл ажиллагаа уялдаж хамтын ажиллагаа, хөдөлмөрийн бүтээмж, дэмжлэг нэмэгдэж ард иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах юм.

Уг захирамжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2018 оны 05 дугаар сарын 01-ний дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг сум, байгууллагын удирдлагуудад үүрэг болгож байна.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/193

Мандалговь

Г Төрийн байгууллагуудын ажлын
цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “л” заалт, аймгийн төр, захиргааны байгууллагууд, иргэд олон нийтийн саналыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд болон Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллага/яам/, ЗГ-ын агентлаг, газруудын ажлын уялдааг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын ажлын цагийг 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд 08 цаг 00 минутанд эхлүүлж 17 цаг 00 минутанд дуусахаар зохицуулахыг аймгийн төрийн байгууллагуудын дарга удирдлагуудад үүрэг болгосугай.

Хоёр. Энэ захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ц.Эрдэнэсүрэн/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О. БАТ-ЭРДЭНЭ

0200579